

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 5 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

Г “ҮЦТТТХТ” ХХК-д нэгдсэн дугаар 7
олгох эрх олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 158 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам”-ын 2.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хөрөнгийн зах зээлд арилжигдах үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох эрхийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд болох “ҮЦТТТХТ” ХХК-д олгосугай.

2. Эрх олгосонтой холбогдуулан үнэт цаасны нэгдсэн дугаарыг олон улсын стандартын дагуу олгоход шаардагдах олон улсын стандартыг хэрэгжүүлэх эрхийг авах, холбогдох олон улсын байгууллагатай гэрээ байгуулан ажиллахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д зөвшөөрсүгэй.

3. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгэлтэй байгаа бүх үнэт цаасанд олон улсын стандарт, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 158 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам”-д заасны дагуу нэгдсэн дугаар олгох ажлыг 2010 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулж, шинээр гарах үнэт цаасанд уг журамд заасны дагуу дугаар олгож байхыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э. Ганбат/, Санхүүгийн зохицуулах хорооноос “ҮЦТТТХТ” ХХК-д нэгдсэн дугаар олгох эрх олгосон тухай олон улсын байгууллагад мэдэгдэхийг Ажлын алба /Х. Бум-Эрдэнэ/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН